




МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ЭХ, ХҮҮХДИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨЛӨӨ

АМЬСГАЛЫН ЦОЧМОГ ХҮНД ХАЛДВАРЫН ҮҮСГЭГЧИЙН ЭМНЭЛЗҮЙН ОНЦЛОГИЙГ СУДАЛСАН НЬ

У.Цэвэгмид, АУ-ны доктор, Дэд профессор,
ЭНЭҮТ-ийн Эмчилгээ эрхэлсэн дэд захирал





СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр жилд улирлын томуугийн нэг тэрбум орчим тохиолдол бүртгэгдэж, 3-5 сая нь хүндэрч, жилд 290 000-аас 650 000 хүн амьсгалын цочмог халдварын улмаас нас бардаг байна.
- Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв (ЭНЭҮТ)-ийн Хүүхдийн эмнэлэгт 2023-2024 оны томуугийн улиралд 444 ор, эрчимт эмчилгээний 25 ор дэлгэж, нийт 22952 хүүхдэд хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг үзүүлсэн бөгөөд АЦХХ-ын үүсгэгчийг полимераз гинжин урвал (ПГУ) шинжилгээгээр ялган дүйж, эмчилгээний тактикийг уялдуулан ажиллах нөхцөл бүрдсэнээр дараах судалгааг хийх үндэслэл бий болсон юм.



СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зорилго:

Амьсгалын цочмог хүнд халдварын үүсгэгчийг тодорхойлж, хүүхдэд илрэх эмнэлзүйн онцлогийг судлах

Зорилт:

1. АЦХХ-ын үүсгэгчийг ПГУ шинжилгээгээр тодорхойлох
2. АЦХХ-ын үүсгэгчийн цаг хугацааны зүй тогтлыг тогтоох
3. АЦХХ-тай хүүхдийн эмнэлзүйн шинж, лаборатори, багажийн шинжилгээний өөрчлөлтийг үүсгэгч тус бүрээр тогтоох



СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

- Судалгааг ЭНЭҮТ-ийн Хүүхдийн эмнэлэгт 2023 оны тавдугаар дугаар сараас 2024 оны хоёрдугаар сард хэвтэн эмчлүүлсэн АЦХХ-ын эмнэлзүйн шинж тод илэрсэн, гэрээр эмчилгээ хийгдээгүй 271 хүүхдийг хамруулсан.
- АЦХХ-ын үүсгэгчийг илрүүлэхдээ хүүхдээс авсан сорьцонд Seeprep32TM ялгах төхөөрөмжийн тусламжтайгаар нуклейн хүчлийг ялгасан.
- Ялгасан нуклейн хүчлийг Allplex RV master assay kit-ийг ашиглан полимеразын гинжин урвал (ПГУ)-ын алтан сатндартын аргаар хийж гүйцэтгэсэн.



СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгааны хүн ам зүй:

Судалгаанд хамрагдсан хүүхдийн дийлэнх нь буюу **59,6%** нь эрэгтэй, **47,8%** нь 1-5 насны хүүхдүүд эзэлж байв.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын нас хүйсийн бүтэц

	Үзүүлэлт	Тоо	Хувь
Хүйс	Эрэгтэй	160	59,6%
	Эмэгтэй	111	40,4%
Нас	2 сар хүртэлх	12	5,1%
	2 сар - 1 нас	78	28,7%
	1 нас – 5 нас	130	47,8%
	5 наснаас дээш	51	18,4%
Нийт		271	100%




СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Дүрслэл 1. Вирусын үүсгэгчийг ПГУ шинжилгээ

Нийт 271 хүүхдэд ПГУ шинжилгээ хийгдэж, 186 хүүхдэд томуу, томуу төст өвчний вирус илэрсэнээс 74,6% нь вирус дангаар, 25,4% нь хавсарсан байдлаар илэрсэн байв.

- **RSV** 18,5% дангаар илэрч, 7,6% хавсарсан,
- **HRV** 15,1% дангаар илэрч, 6,9% хавсарсан,
- **ADV** 4,4% дангаар илэрч, 7% хавсарсан,
- **PIV** 8,5% дангаар илэрч, 3,3% хавсарсан,
- **MPV** 2,6% дангаар илэрч, 0,4% хавсарсан,
- **Flu A B** 1,1% дангаар илэрч, 0,4% хавсарсан
- **Covid-19** 1,1% дангаар илэрсэн.

Вирус
271 responses






СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Flu A нь 5 сард, **Flu B** нь 11 сард,
RSV нь 5, 12 сард илүү тохиолдсон,
HRV халдвар 9 дүгээр сард илүү тохиолдсон

PIV болон **MPV** халдвар 10 дугаар сард,
ADV халдвар 2 дугаар сард илүү тохиолдсон байв.

Дүрслэл 2. АЦХХ-ийн үүсгэгч (тоо, сараар)






СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Томуугийн Flu A, B вирус илэрсэн хүүхдийн 33% нь сатураци 90%-иас доош унаж, 66% нь хатгалгаагаар хүндэрсэн байв.

Дүрслэл 3. Томуугийн A, B вирусын халдварын эмнэлзүйн шинж (n=3)






СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Амьсгалын синситиаль вирус (RSV) илэрсэн хүүхдийн 60% нь шуугиантай амьсгал илэрч, 68% нь амьсгаадах, 41% нь хөхрөх шинж илэрч, 33% нь сатураци 90%-иас буурч, 60% нь хатгалгаагаар хүндэрч, амьсгал дутал илэрсэн байв.

Дүрслэл 4. Амьсгалын синситиаль вирус (RSV)-ын халдварын эмнэлзүйн шинж (n=50)






СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Аденовирус (**ADV**) илэрсэн хүүхдийн 50% нь амьсгаадах, 16,6% нь хөхрөх шинж илэрч, 41% нь сатураци 90%-иас буурч, 83% нь хатгалгаагаар хүндэрч, амьсгал дутал илэрсэн байв.

Дүрслэл 5. Аденовирусын халдварын эмнэлзүйн шинж (n=12)






СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Параинфлуэнза вирус (**PIV**) илэрсэн хүүхдийн 56% нь шингэн цайвар нустай, 52% нь хатгалгаагаар хүндэрсэн байв.

Дүрслэл 6. Параинфлуэнза вирусын халдварын эмнэлзүйн шинж (n=23)






СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Риновирус (HRV) илэрсэн хүүхдийн 40% нь амьсгаадах, 75% нь хамраас өтгөн нус гарах, 28% нь хөхрөх шинж илэрч, 14-16% нь хатгалгаагаар хүндэрсэн байв.

Дүрслэл 7. Риновирусын халвдарын эмнэлзүйн шинж (n=41)






СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Метапневмовирус (MPV) илэрсэн хүүхдийн 66% нь хамраас шингэн нус гарах, 33% нь сатураци 90% доош буурч, 33% нь хөхрөх, 33% нь шуугиантай амьсгал илэрч, 50% нь хатгалгаагаар хүндэрсэн байв.

Дүрслэл 8. Метапневмовирус (MPV) халдварын эмнэлзүйн шинж (n=7)





СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хавсарсан вирусын халдварын тохиолдол 25,4%-ийг эзэлж, **HRV+RSV**, **ADV+RSV+PIV**, **PIV+RSV** хавсарсан халдвар эмнэлзүйн хувьд хүнд явцтай, амьсгал дутлын шинжүүд давамгайлсан илэрч байв.

Хүснэгт 2. Хавсарсан вирусын халдварын эмнэлзүйн шинж


Хавсарсан вирус	Эмнэлзүйн шинж					
	Ханиалгах	Хөхрөлт	Сатураци 90% доош	Халуурах (38,5хэм дээш)	Амьсгаадах	Шуугиант амьсгал
FluA+RSV	+	-	-	+	-	+
ADV+HRV	+	+/-	+/-	-	+/-	+
ADV+RSV	+	-	-	+	-	+
ADV+RSV+PIV	+	+	+	+	+	+
HRV+ADV	+	+	+	-	+	+/-
HRV+RSV	+	+	+	+	+	+
MPV+HRV	+	-	-	+	-	-
MPV+HRV+PIV	+	-	-	+	-	-
MPV+RSV	+	-	-	+/-	-	-
PIV+ADV	+	-	+/-	+	+	-
PIV+ADV+HRV	+	-	-	+	+/-	+/-
PIV+ADV+HRV+RSV	+	-	-	+	-	+
PIV+HRV	+	+	+/-	+	-	+/-
PIV+HRV+RSV	+	-	-	+	+	+
PIV+RSV	+	+	+	+	+	+
MPV+ADV+HRV	+	+/-	+	+/-	+	+



СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Рентген шинжилгээгээр **HRV+RSV** хавсарсан халдварын шалтгаант хатгалгааны 60% нь нэвчдэст, **ADV+HRV** хавсарсан тохиолдлын 75% нь голомтот өөрчлөлт илэрсэн байв.

Дүрслэл 9. Хавсарсан вирусын халдварын рентген шинжилгээний өөрчлөлт






СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Ор хоногийн хувьд **57% нь 7-9 хоног**, 18,8% нь 5-6 хоног, 18,8% нь 10-14, **5,4% нь 14 хоногоос дээш** байв.

Дүрслэл 10. Хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн ор хоног

Ор хоног
272 responses





ДҮГНЭЛТ

1. Судалгаанд хамрагдсан 271 хүүхдийн 68.6% нь **томуу, томуу төст өвчний вирус** илэрч, 74,6% нь вирус дангаар, 25,4% нь вирус хавсарсан байдлаар тодорхойлогдсон бөгөөд **RSV** нь 18.5% илэрч, 7.6% хавсарсан, **HRV** нь 15.1% илэрч, 6,9% хавсарсан, **ADV** нь 4,4% илэрч, 7% хавсарсан, **PIV** нь 8,5% илэрч, 3,3% хавсарсан, **MPV** 2,6% илэрч, 0,4% хавсарсан, **Flu A, B** нь 1,1% илэрч, 0,4% хавсарсан, **Covid-19** 1,1% дангаар тодорхойлогдсон.
2. Судалгаагаар томуугийн вирус 2023 оны 5 сард **Flu A** , 11 сард **Flu B** тохиолдсон байв. Томуу төст өвчний вирус **RSV** нь 5, 12 сард илүү тохиолдсон, **HRV** халдвар 9 дүгээр сард илүү, **PIV** болон **MPV** халдвар 10 дугаар сард, **ADV** халдвар 2 дугаар сард илүү тохиолдсон байв.



ДҮГНЭЛТ

3. Томуугийн **Flu A, B** вирус илэрсэн хүүхдийн 66%, **томуу төст өвчний вирус RSV** 60%, **ADV** 83%, **PIV** 52%, **MPV** 50% нь хатгалгаагаар хүндэрсэн. **HRV+RSV, ADV+RSV+PIV, PIV+RSV** хавсарсан халдвар эмнэлзүйн хувьд хүнд явцтай, амьсгал дутлын шинжүүд давамгайлан илэрч байв.

Рентген шинжилгээгээр **HRV+RSV** хавсарсан халдварын шалтгаант хатгалгааны 60% нь нэвчдэст, **ADV+HRV** хавсарсан тохиолдлын 75% нь голомтот өөрчлөлт илэрсэн байв.

Ор хоногийн хувьд **57% нь 7-9 хоног**, 18,8% нь 5-6 хоног, 18,8% нь 10-14, **5,4% нь 14 хоногоос дээш** хугацаагаар эмчлэгдсэн байв.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

